

# Дархлаажуулалт болон вакцин үйлдвэрлэлийн талаарх анагаах ухааны нэр ТОМЪЁОНЫ ТОЛЬ

**КОВИД-19 дархлаажуулалтын  
хөтөлбөрийн хүрээнд харилцаа  
холбоог дэмжих нь.**

Glossary of Medical Terminology for  
**Immunisation and Vaccine development**

Produced by Health and Social Policy Branch NSW Ministry  
of Health, NSW Multicultural Health Communication Service,  
NSW Refugee Health Service and School of Population Health,  
University of New South Wales



**UNSW**  
SYDNEY

### **КОВИД-19 дархлаажуулалтын хөтөлбөрийн хүрээнд харилцаа холбоог дэмжих нь**

Энэхүү тайлбар толь нь нийгмийн бүлгийн байгууллагууд, орчуулагч болон хэлмэрчид, хос хэлээр ярьдаг албан хаагчид, мөн нийгмийн бүлгийн удирдагчдад вакцин үйлдвэрлэлт болон хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж хоорондоо харилцахад нь туслах зорилгоор бүтээгдсэн юм.

### **Анхааруулга**

Энэхүү тайлбар толь нь дархлаажуулалт болон вакцин үйлдвэрлэлтийн талаарх эмнэлгийн нарийн төвөгтэй нэр томъёог энгийн хэллэгээр тайлбарлахыг зорьсон болно. Доорх мэдээллийг зөвхөн лавлах хэрэгсэл болгон ашиглана.

Хэрвээ та энэхүү жагсаалтад санал хүсэлт илгээх эсвэл шинэ үг, нэр томъёо нэмж оруулахыг хүсвэл Туслах Профессор Холли Сиэл-тэй [h.seale@unsw.edu.au](mailto:h.seale@unsw.edu.au) эсвэл +61 (02) 9385 3129 утсаар холбогдоно уу.

### **Талархал**

Энэхүү материалыг боловсруулсан:

- Associate Professor Holly Seale, School of Population Health, University of New South Wales
- Lisa Woodland, Director, NSW Multicultural Health Communication Service
- Dr Kylie Quinn, School of Health and Biomedical Sciences; RMIT University
- Dr Sabira Shrestha, National Centre for Immunisation Research and Surveillance (NCIRS)
- Vicky Jacobson, Coordinator, Refugee Health Network Queensland
- Dr Carissa Bonner, The School of Public Health, University of Sydney

### **Гүн талархал:**

Энэхүү тайлбар толийг хянасан дараах хүмүүст гүнээ талархал илэрхийлье.

- Associate Professor Christopher Blyth, Wesfarmers Centre of Vaccines and Infectious Diseases, Telethon Kids Institute.
- Dr Nadia Chaves
- Benine Muriithi, Patricia Argüello de Avila and Mariam Elliott, Refugee Health Network Queensland
- Fartih Karakas and Ismail Akinci, All Graduates
- Dr Jan Fizzell, Senior Medical Advisor, Public Health Response Branch, NSW Health

### **Талархал**

Бодит (одоо) цагийн онлайн редактор ашиглан үгийн утга, тайлбар шалгах Эрүүл Мэндийн Нэр Томъёоны Лаборатори (Ayre, J., et al. (2021). *Sydney Health Literacy Lab (SHLL) Health Literacy Editor*). Хаанаас <https://hdl.handle.net/2123/24642>

# Агуулга

A 4

M 16

B 6

N 17

C 7

O 18

D 9

P 19

E 10

R 21

G 11

S 22

H 12

T 23

I 13

V 24

L 15

W 26



# A

## **Adverse event (reaction)**

Any unexpected or serious effect that happens after a vaccine or medicine. Something that was not expected to happen.

## **Гаж гөлөө (хариу урвал)**

Вакцин болон эмийн эмчилгээний дараа ямар нэгэн тооцоолоогүй эсвэл ноцтой үр нөлөө илрэх. Урьдчилан тооцоолоогүй зүйл тохиолдох.

## **Adverse event following immunisation (AEFIs)**

An unexpected effect that happens after vaccination. The vaccine may have not been the reason for the problem.

## **Дархлаажуулалтын дараах гаж нөлөө (AEFIs)**

Вакцинжуулалтын дараа илрэх тооцоолоогүй үр нөлөө. Вакцин нь тухайн асуудлын шалтгаан биш байж болно.

## **Advisory Committee on Vaccines (ACV)**

A group of experts that gives medical and scientific advice. The group talks to the Australian Government's Minister for Health and the Therapeutic Goods Administration (TGA). They give advice on issues about vaccine safety and use.

## **Дархлаажуулалтын Зөвлөх Хороо (ACV)**

Анагаах ухаан болон шинжлэх ухааны зөвлөмж өгдөг мэргэжилтнүүдийн баг. Энэхүү баг нь Австралийн Засгийн Газрын Эрүүл Мэндийн Яам болон Эм, Эмийн Бүтээгдэхүүнийг Хянах Газартай (TGA) хамтран ажилладаг. Мөн энэ байгууллага нь вакцины аюулгүй байдал болон хэрэглээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгдөг.

## **Allergy**

An immune response to a foreign material that is harmless to most people. The foreign material could be food, medicine or a part of a vaccine.

## **Харшил**

Ихэнх хүнд хортой нөлөө үзүүлдэггүй гадны биетийн эсрэг бие махбодод илэрч буй дархлааны хариу урвал. Тухайн гадны биет нь хоол хүнс, эмийн бодис эсвэл вакцины нэг бүрэлдэхүүн хэсэг байж болно.

## **Antibody**

When the body gets sick or gets a vaccine, the body will make antibodies to protect it against that disease.

The body can then recognise the germs when that same disease happens again.

## **Эсрэг бие**

Хүний бие өвчлөх эсвэл вакцин хийлгэхэд тухайн өвчнөөс өөрийгөө хамгаалах эсрэг биетүүдийг ялгаруулдаг.

Ингэснээр уг өвчин дахин илрэхэд хүний бие тухайн бичил биетнүүдийг таних чадвартай болдог.

## **Antigen**

A foreign (external) substance like bacteria, viruses, or fungi that cause infection and disease if they get inside the body. The immune system detects them and produces antibodies to fight them.

## **Антиген**

Хүний биед орсон тохиолдолд халдварт өвчин үүсгэх чадвартай бактери, вирус, мөөгөнцөр гэх зэрэг гадны биетийг хэлнэ. Дархлааны систем нь эдгээрийг илрүүлэн тэмцэх эсрэг бие үүсгэдэг байна.



## A Cont'd

### **Adjuvant**

An adjuvant is an ingredient used in some vaccines. It helps our bodies make a stronger immune response. The adjuvant works together with other parts of the vaccine. They have been used in some vaccines for over 70 years.

### **Туслах эм (Adjuvant)**

Туслах эм (Adjuvant) гэдэг нь зарим төрлийн вакциныг үйлдвэрлэхэд ашигладаг орц юм. Энэ нь бидний бие махбодын дархлааны хариу урвалыг илүү хүчтэй болгоход тусалдаг. Туслах эм нь тухайн вакцины бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хамтран үйлчилдэг ба эдгээрийг сүүлийн 70 гаруй жилийн турш зарим төрлийн вакциныг үйлдвэрлэхэд ашигласаар ирсэн.

### **Anaphylaxis**

A quick and serious allergic reaction. This could be a reaction to food or medicine. Symptoms can include breathing difficulties, loss of consciousness and a drop in blood pressure. The person will need urgent medical attention and can sometimes die.

### **Анафилакс**

үргэн бөгөөд ноцтой харшлын урвал. Энэ нь хоол хүнс эсвэл эмэнд үзүүлж буй хариу урвал байж болно. Шинж тэмдгүүдэд амьсгалын саатал, ухаан балартах болон цусны даралт багасах зэрэг орно. Тухайн хүнд яаралтай эмнэлэгийн тусламж хэрэгтэй болох ба зарим тохолдолд амь насанд хүрэх аюултай.

### **Association**

A link between one event taking place at the same time as another event. The fact that they are happening together does not prove that one event caused the other event.

### **Уялдаа холбоо**

Нэг цаг хугацаанд тохиолдож буй өөр үйл явдлын хоорондын холбоо. Үйл явдлууд зэрэг тохиолдож байгаа нь нэг үйл явдал нөгөөгийнхөө шалтгаан болсон гэдгийг батлах боломжгүй.

### **Asymptomatic**

Someone with no sign of infection.

### **Шинж тэмдэггүй**

Ямар ч халдварын шинж тэмдэггүй хүн.

### **Attenuated vaccine**

Live vaccines use a less strong (or attenuated) form of the germ that causes a disease. These vaccines are like the natural infection that they help prevent. They create a strong and long-lasting immune response.

### **Сулруулсан вакцин**

Амьд вакцинуудад өвчин үүсгэгч бичил биетнүүдийн хүч багатай (эсвэл сулруулсан) хувилбарыг ашигладаг. Эдгээр вакцинууд нь тэдний хамгаалахаар зорьдог байгалийн халдвартай адил шинжтэй ба илүү хүчтэй ба удаан хугацааны дархлааны хариу урвал үүсгэдэг.

### **Australian Technical Advisory Group on Immunisation (ATAGI)**

A group of experts that helps the Government to make decisions on the use of vaccines in Australia.

### **Австралийн Дархлаажуулалтын Техникийн Зөвлөх Баг (ATAGI)**

Австрали улсын вакцины хэрэглээний асуудлаар Засгийн газарт шийдвэр гаргахад нь тусладаг мэргэжилтнүүдийн баг.

### **Australian Immunisation Register**

An electronic register that contains information on all vaccines given to all Australians.

### **Австралийн Дархлаажуулалтын Бүртгэл**

Австралийн ард иргэдэд хийгдсэн бүх вакцинуудын мэдээллийг хадгалдаг цахим бүртгэл.



# B

**Batch assessment**

A process of checking that the vaccines used in Australia are of high quality. The Therapeutic Goods Administration will do these checks.

**Багцын үнэлгээ**

Австралид ашиглагдах вакцинууд чанарын өндөр түвшинд байгааг шалгах процесс. Эм, Эмийн Бүтээгдэхүүнийг Хянах Газар (TGA) эдгээр үнэлгээг хийдэг.

**Boost (Booster injection)**

An additional vaccine after the first one, given to either build up better immunity or to make sure the immunity lasts longer.

**Нэмэлт (Boost) (Нэмэлт тарилга)**

Эхний тунгийн дараа дархлааг илүү сайжруулах эсвэл дархлааг удаан тогтоох зорилгоор хийх нэмэлт вакцин.

**Breakthrough infection**

When someone can get the infection even though they are vaccinated.

**Вакцины хамгаалалтыг давсан (Breakthrough) халдвар**

Тухайн хүн вакцинд хамрагдсан хэдий ч халдвар авахыг хэлнэ.



# C

## **Coalition for Epidemic Preparedness Innovations (CEPI)**

An international organisation that will help many countries gain access to COVID-19 vaccines. It will help governments, including lower income countries, to access safe and effective vaccines for 20% of their population.

## **Цар Тахалтай Тэмцэх Бэлэн байдал, Инновацийн Эвсэл (CEPI)**

Улс орнуудад КОВИД-19 вакцинжуулалтыг хүртээмжтэй байлгахад тусладаг олон улсын байгууллага. Энэ байгууллага нь ялангуяа бага орлоготой орнуудад хүн амынхаа 20%-г аюулгүй, үр дүнтэй вакцинаар хангахад нь засгийн газруудад тусалдаг.

## **Cell culture**

Using cells grown in liquid to make vaccine ingredients.

## **Эсийн өсгөвөр**

Шингэнд ургуулсан эсүүдийг ашиглан вакцины хольцыг бэлдэх.

## **Clinical Trial**

A type of research study. People either receive a new vaccine or are in the control group. The control group may receive a different vaccine or a placebo, meaning a simple substance with no effects on the body. Participants usually do not know which group they are in. Scientists test the safety and benefits of new vaccines.

## **Эмнэлзүйн Туршилт**

Судалгааны нэг төрөл. Хүмүүс нэг бол шинэ вакцин хийлгэх бүлэгт эсвэл хяналтын бүлэгт хамрагдана. Хяналтын бүлгийн хүмүүс өөр төрлийн вакцин хийлгэх эсвэл бие махбодод ямар нэгэн нөлөөгүй энгийн бодис болох плацебо хэрэглэнэ. Оролцогчид ихэнхдээ өөрсдийгөө аль бүлэгт хамрагдсанаа мэддэггүй. Эрдэмтэд шинэ вакцины аюулгүй байдал болон үр дүнг судалдаг.

## **Co-administration**

To be given more than one vaccine on the same day.

## **Давхар хэрэглээ**

Нэгээс олон вакциныг нэг өдөр хийлгэх.

## **Cold chain**

Shipping and storing vaccines at the correct temperature.

## **Хүйтэн хэлхээ**

Вакциныг зөв хэмд хадгалж, тээвэрлэх.

## **Combination vaccine**

Combination vaccines take two or more vaccines that could be given individually and put them into one shot.

## **Хосолсон вакцин**

Хосолсон вакцинууд нь нэг хүнд хийж болох 2 болон түүнээс дээш вакцинуудыг нэг тунд багтаасан байна.

## **Convalescent plasma**

Plasma is the liquid part of blood. It is collected from a person after they have had an infection. The liquid contains antibodies against the germ. Sometimes this plasma can be given to other people to prevent them getting sick or to help them get better.

## **Эдгэрсэн хүний сийвэн**

Сийвэн гэдэг нь хүний цусны шингэн хэсэг. Халдвар авсны дараа тухайн хүнээс шинжилгээгээр цусны сийвэнг авдаг. Энэ шингэн нь бичил биетнүүдийн эсрэг тэмцэх эсрэг биетүүдийг өөртөө агуулж байдаг. Заримдаа энэ шингэнийг өвчнөөс урьдчилан сэргийлэх эсвэл эдгэрэхэд нь туслах зорилгоор бусад хүмүүст эмчилгээгээр хийдэг.



## C Cont'd

### **Conjugate vaccine**

The joining together of two compounds (usually a protein and polysaccharide) to increase a vaccine's effectiveness.

### **Control group**

A group of people who do not receive the vaccine or drug being tested. Instead, they may get the normal intervention (drug, vaccine, or treatment), a placebo or nothing. The aim of the trial is to compare what happens in each group. The results must be different enough between the two groups to prove that the difference has not just occurred by chance.

A placebo is a 'dummy' treatment, such as a sugar pill, that looks the same.

### **Contraindication**

An illness (or health condition) that increases the risk for a serious adverse health consequence.

### **COVAX**

An international partnership that aims to support the development and delivery of the COVID-19 vaccines fairly around the world.

### **Нийлмэл вакцин**

Вакцины үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор хоёр бодисыг (голдуу уураг болон полисахарид) нэгтгэх.

### **Хяналтын бүлэг**

Туршилтын вакцин эсвэл эм танг хэрэглээгүй бүлэг хүмүүс. Оронд нь тэдэнд энгийн интервенц (эмийн бэлдмэл, вакцин эсвэл эмчилгээ), плацебо өгөх буюу эсвэл юу ч өгөхгүй. Энэхүү туршилтын гол зорилго нь 2 бүлгийн өөрчлөлтийг харьцуулах явдал юм. 2 бүлэгт гарсан өөрчлөлтүүд санамсаргүй тохиолдоогүйг батлахын тулд үр дүн нь хангалттай ялгаатай байх ёстой.

Плацебо бол харагдах байдлаараа адил боловч сахарын үрэл зэргээр хийсэн зохиомол эмчилгээ юм.

### **Эсрэг заалт**

Эрүүл мэндийн ноцтой сөрөг үр дагаварт хүргэх эрсдлийг нэмэгдүүлдэг өвчин (эсвэл эрүүл мэндийн нөхцөл байдал).

### **КОВАКС**

КОВИД-19 вакцины үйлдвэрлэлт болон вакциныг дэлхий даяар тэгш хүртээмжтэй хуваарилахад тусладаг олон улсын хамтын ажиллагаа.





# D

**Deltoid**

A muscle in the upper arm where vaccine is given.

**Делтойд**

Вакцин хийгддэг гарын дээд хэсгийн булчин.

**Dose**

An amount of a medicine or drug taken.

**Тун**

Эм эсвэл эм танг хэрэглэх хэмжээ.

**Dose/vaccination schedule**

A list of times to have vaccines throughout your life.

**Тун/дархлаажуулалтын товлол**

Таны амьдралын турш хийгдэх вакцинуудын тов бүхий жагсаалт.

**Dosing error**

When medicines are given in the wrong amount, at the wrong time point or to the wrong person.

**Тунгийн алдаа**

Аливаа эмийг буруу хэмжээгээр, буруу цагт эсвэл буруу хүнд хэрэглэх.



# E

<p><b>Efficacy</b> How well a vaccine works during a research study.</p>	<p><b>Үр ашиг</b> Судалгааны явц дах вакцины нөлөөлөл.</p>
<p><b>Effectiveness</b> How well a vaccine works in the real world.</p>	<p><b>Үр дүн</b> Бодит амьдрал дээрх вакцины нөлөөлөл.</p>
<p><b>Endemic</b> When there are low levels of a disease in a town, city or country.</p>	<p><b>Нутагшмал</b> Тодорхой нэг улс, хот эсвэл дүүрэгт тухайн өвчлөлийн түвшин бага байх тохиолдол.</p>
<p><b>Epidemic</b> A widespread amount or rapid increase of an infectious disease in a community at a particular time. More cases than normal.</p>	<p><b>Тахал</b> Тодорхой цаг үед нийгмийн тодорхой бүлэгт халдварт өвчин их хэмжээгээр эсвэл хурдацтайгаар нэмэгдэн тархах. Хэвийн үеэс олон тохиолдлууд илрэх явц.</p>
<p><b>Epidemiology</b> The study of how often diseases occur in different groups of people and why.</p>	<p><b>Өвчний тархалт судлал</b> Тухайн бүлэг хүмүүст тохиолдож буй өвчний давтамж болон шалтгаан судлал.</p>
<p><b>Elimination of infection</b> Zero cases of an infection in a specified geographic area (i.e. a country). Example: Measles in Australia.</p>	<p><b>Халдвар арилах</b> Газарзүйн тодорхой хэсэгт (тухайлбал нэг улсад) халдварын тохиолдол тэг болох. Жишээ нь: Австрали дах улаан бурхан.</p>
<p><b>Eradication</b> Zero cases of the germ in the entire world. Example: Smallpox.</p>	<p><b>Устах</b> Дэлхий даяар тухайн бичил биетний тохиолдол тэг болох. Жишээ нь: Салхин цэцэг.</p>
<p><b>Extensive limb swelling</b> When the arms or legs of a person become larger than normal, sometimes twice the normal size, with or without redness, close to where the vaccine was given.</p>	<p><b>Мөчний хэт хавагнал</b> Тухайн хүний хөл эсвэл гар хэвийн үеэсээ томрох ба зарим тохиолдолд хэвийн хэмжээнээсээ хоёр дахин, улайлттай эсвэл улайлтгүй, мөн вакцин хийлгэсэн хэсгийн ойролцоо томордог.</p>



## G

### **Guillain-Barré syndrome**

A rare event where a person's immune system attacks the nerves and can cause muscle weakness, numbness or not being able to move part or most of the body.

### **Guillain-Barré-н хам шинж**

Тухайн хүний дархлааны тогтолцоо нь өөрийн мэдрэлүүд рүүгээ довтолсны улмаас булчин сулрах, мэдээ алдах мөн бүх биеэ эсвэл биеийн зарим хэсгээ хөдөлгөх чадваргүй болох шинжүүдээр илэрдэг ховор үзэгдэл.



# Н

**Herd immunity**

When most people in a community have protection against an infection. High levels of protection make it more and more difficult for the germ to pass from person to person. This can successfully stop the spread of disease in the community.

**Сүргийн дархлаа**

Тухайн нийгмийн бүлэгт ихэнх хүмүүс халдварын эсрэг хамгаалалт буюу дархлаатай болох. Хүний бие нь өндөр хамгаалалттай байвал тухайн бичил биет хүнээс хүнд дамжихад илүү хэцүү байх болно. Ингэснээр тухайн нийгмийн бүлэгт халдварын тархалтыг амжилттай зогсоох боломжтой.



<p><b>Immune system</b> The body's system for identifying and killing germs to protect us against infection and disease. It involves making antibodies that move in the blood, recognize foreign substances like bacteria and viruses, and attach to them. It signals to the body to get rid of the foreign substances.</p>	<p><b>Дархлааны систем</b> Гадны бичил биетнүүдийг таньж устган биднийг аливаа өвчин болон халдвараас хамгаалдаг хүний бие махбодын систем. Энэ нь бактери, вирус зэрэг гадны бодисыг танин илрүүлж, тэднийг бүслэн холбогддог эсрэг биетүүдийг цусанд ялгаруулах систем юм. Ингэснээр бие махбодод тухайн гадны бодисыг зайлуулах дохио болж өгдөг.</p>
<p><b>Immune response</b> The immune response is how your body recognizes and defends itself against bacteria, viruses, and substances that appear foreign and harmful.</p>	<p><b>Дархлааны хариу урвал</b> Дархлааны хариу урвал бол бие махбод бактери, вирус болон гадны хортой ямар нэгэн бодисыг таньж илрүүлэн өөрийгөө хамгаалж байгаа хэрэг юм.</p>
<p><b>Immune thrombocytopenia purpura (ITP)</b> A rare event where a person's immune system destroys the blood clotting cells. This results in a person's blood not being able to clot as it should.</p>	<p><b>Иммуни Тромбоцитопени Пурпура (ИТР)</b> Тухайн хүний дархлааны тогтолцоо нь өөрийн цусан дах бүлэгнүүлэгч эсүүдээ устгадаг ховор үзэгдэл. Энэ нь тухайн хүний цус өөрөөрөө бүлэгнэх чадваргүй болоход хүргэдэг.</p>
<p><b>Immunity</b> Being able to avoid getting sick or avoid getting infected when exposed to a germ. Your body builds this immunity by either being exposed to the germs or by getting a vaccine. Your immune system has a "memory"- it can remember germs that it has seen previously and knows how to attack them.</p>	<p><b>Дархлаа</b> Бичил биетэн биед нэвтрэхэд өвчлөхгүй эсвэл халдвар авахгүй байх чадвар. Таны бие махбод энэхүү дархлааг тухайн бичил биетэн биед нь нэвтрэхэд эсвэл вакцин хийлгэснээр тогтоодог. Таны дархлааны систем өмнө нь харж байсан бичил биетнээ таних "ой санамжтай" ба хэрхэн тэмцэхээ мэддэг болдог.</p>
<p><b>Immunisation</b> The process of developing immunity to an infection, usually by getting vaccinated.</p>	<p><b>Дархлаажуулалт</b> Голдуу вакцин хийлгэж ямар нэгэн халдварт дархлаа үүсгэх процесс.</p>
<p><b>Immunocompromised</b> Someone whose immune system may not be able to fight off an illness as well as other people. There are several illnesses that can cause someone to become immunocompromised.</p>	<p><b>Дархлаа суларсан</b> Тухайн хүний дархлааны тогтолцоо аливаа өвчний эсрэг бусад хүмүүсийн адил тэмцэх чадваргүй болох. Хүнийг дархлааны сулралд хүргэдэг хэд хэдэн өвчнүүд байдаг.</p>
<p><b>Immunogenicity</b> The power of a substance to produce an immune response. The substance can be present in a vaccine.</p>	<p><b>Иммуноген чанар</b> Аливаа бодисын дархлааны хариу урвал үүсгэх хүч чадал. Уг бодис нь вакцинд агуулагдсан байж болно.</p>



## I Cont'd

### **Inactivated vaccine**

A vaccine made from a germ that has been killed. The germ is killed either by high heat or by chemicals. When this killed germ is injected into your body, it helps your immune system learn to find the germ, without the risk of getting sick.

### **Идэвхгүйжүүлсэн вакцин**

Амьгүй бичил биетнээс гаргаж авсан вакцин. Бичил биетнийг өндөр температур эсвэл химийн бодисоор үхжүүлсэн байна. Энэхүү амьгүй болсон бичил биетнийг таны биед тарихад өвчлөх эрсдэлгүйгээр таны дархлааны систем тухайн бичил биетийг таних чадвартай болно.

### **Incidence**

Incidence can mean the number of new disease cases in a town, city, state or country or the number of new cases in a particular group of people over a certain amount of time.

### **Тохиолдол**

Тохиолдол гэдэг нь тодорхой нэг улс, муж, хот эсвэл дүүрэгт гарсан шинэ өвчлөлийн тоог эсвэл тодорхой нэг хугацаанд хэсэг бүлэг хүмүүсийн дунд гарсан шинэ өвчлөлийн тоог илэрхийлж болно.

### **Infection**

When a germ (bacteria or virus) enters the body. If the body cannot fight the growth of germs, it may cause disease.

### **Халдвар**

Хүний бие махбодод микроб (нян эсвэл вирус) орох. Хэрвээ хүний бие махбод тухайн микробын үржилтэй тэмцэж чадахгүй бол энэ нь өвчин болдог.

### **Injection site reaction**

The most common side-effects after a vaccine. This can include pain, itching, swelling or redness around the site of injection. These are usually mild and last for 1–2 days.

### **Тарьсан хэсгийн хариу урвал**

Вакцины хийлгэсний дараа хамгийн түгээмэл тохиолддог гаж нөлөө. Үүнд тарьсан хэсгийг тойрон хөндүүрлэх, загатнах, хавагнах эсвэл улайх шинжүүд орно. Энэ нь ихэнхдээ хөнгөн бөгөөд 1-2 өдөр үргэлжилдэг.

### **Intramuscular injection**

Where the vaccine is given into the muscle.

### **Булчин тариа**

Вакциныг булчинд хийх.



# L

## **Lipid**

Lipid is fat that is used to make a protective bubble around the mRNA in mRNA vaccines. mRNA is a type of small molecule. mRNA is very weak and breaks down quickly in the body if it is not protected. Once the mRNA is transported into the cell, it is broken down inside the cell.

## **Липид**

Липид гэдэг нь mRNA вакцин дах mRNA-г тойрсон хамгаалалтын хөөс үүсгэх зорилгоор ашигладаг өөх тос юм. mRNA бол жижиг молекулын нэг төрөл ба хамгаалалтгүй бол хэврэг, хүний биед амархан задардаг. mRNA эсийн дотор ороод задардаг.

## **Live vaccine**

The vaccine uses a live form of the bacterium/virus that may be weakened.

## **Амьд вакцин**

Амьд нян/вирусын хоруу чанарыг сулруулж бэлтгэсэн вакцин.

## **Long-COVID (also known as post-covid condition)**

When people with COVID-19 have symptoms for two months or more. Common symptoms include feeling tired, shortness of breath, memory problems, and others. These symptoms can affect the person's daily functioning.

## **Урт хугацааны-КОВИД (ковидын дараах нөхцөл байдал гэж мөн нэрлэгддэг)**

КОВИД-19-н халдвар авсан хүнд 2 болон түүнээс дээш сарын турш шинж тэмдгүүд илрэх. Үүнд ядрах, амьсгал давчдах, ой санамж өөрчлөгдөх болон бусад түгээмэл шинж тэмдгүүд орно. Эдгээр нь тухайн хүний өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх магадлалтай.



# M

## **Messenger RNA (mRNA)**

A type of small molecule that your cells use as instructions to make protein. mRNA tells your cells how to put together a specific protein using building blocks (called amino acids). You have many millions of mRNA molecules in your body at any one time- all being used to make proteins.

## **Тээвэрлэгч RNA (mRNA)**

Таны эс уураг нийлэгжүүлэхдээ зааварчилгаа болгон ашигладаг жижиг молекулын нэг төрөл. mRNA таны эсэд бүтцийн блокуудыг (амино хүчлүүд гэдэг) ашиглан хэрхэн тодорхой нэг уураг бүтээхийг заадаг. Таны биед олон сая mRNA молекулууд нэгэн зэрэг бүгд уураг нийлэгжүүлэхээр ажиллаж байдаг.

## **Minimum interval**

The amount of time a person needs to leave between receiving their 1st and 2nd vaccines.

## **Минимум давтамж**

Вакцины 1 болон 2-р тун хоорондын завсарлах хугацаа.

## **Mixed (heterologous) schedules**

Sometimes a different mixture, brand or vaccine platform may be given for the second vaccine.

## **Холимог (гетерологи) товлол**

Зарим үед вакцины 2-р тунд холимог, өөр үйлдвэрийн, эсвэл өөр вакцины платформыг ашиглан хийх тохиолдол байдаг.

## **mRNA vaccine**

mRNA vaccines teach our cells how to make a harmless protein—or even just a piece of a protein. This protein activates an immune response inside our bodies. That immune response, which produces antibodies, is what protects us from getting very unwell if the real virus enters our bodies.

## **mRNA вакцин**

mRNA вакцин бидний эсүүдэд хэрхэн хоргүй уураг эсвэл зүгээр энгийн уураг нийлэгжүүлэхийг зааж өгдөг. Энэ уураг нь бидний биед дархлааны хариу урвалыг идэвхжүүлдэг. Харин дархлааны хариу урвалын үр дүнд эсрэг биетүүд үүсэх ба энэ нь жинхэнэ вирус биед ороход биднийг хүндээр өвчлөхөөс хамгаалдаг.

## **Morbidity**

Illness that happens due to a specific infection or condition.

## **Өвчлөлт**

Тодорхой нэг халдвар эсвэл нөхцөл байдлаас шалтгаалан үүсдэг өвчин.

## **Mortality**

Deaths that happen due to a specific infection or condition.

## **Нас баралт**

Тодорхой нэг халдвар эсвэл нөхцөл байдлаас шалтгаалсан нас баралт.

## **Multi-dose vial**

The containers (vials) hold more than one dose of a medicine or vaccine in a single vial.

## **Олон-тунт хуруу шил**

Нэг хуруу шилэнд нэгээс олон эм болон вакцины тунг багтаах чадамжтай савнууд (хуруу шилнүүд).

## **Myocarditis**

A disease where the heart muscle becomes inflamed.

## **Миокардит**

Зүрхний булчингийн үрэвсэл үүсгэдэг өвчин.





# N

## **National Immunisation Programme (NIP)**

The vaccines that are given for free in Australia to children, adolescents and adults.

## **Дархлаажуулалтын Үндэсний Хөтөлбөр (NIP)**

Австрали улсад хүүхэд, өсвөр үе болон насанд хүрэгчдэд үнэгүй хийгдэж буй вакцинууд.

## **Neutralisation**

One way that our immune system can protect us from an infection. Our immune system makes antibodies that stick all over the surface of a virus. When the virus tries to stick onto our cells, the antibodies get in the way and stop the virus from getting into our cells. They also help other parts of the immune system recognise and destroy the virus.

## **Саармагжуулалт**

Халдвараас хамгаалах бидний дархлааны системийн бас нэгэн арга. Бидний дархлааны систем вирусын гадаргууг бүрхэн наалддаг эсрэг биетүүдийг ялгаруулдаг. Вирус хүний биеийн эсэд холбогдохоос өмнө эсрэг биетүүд тэдэнд саад болон эс дотор орохоос хамгаалдаг. Мөн тэд дархлааны системийн бусад бүрэлдэхүүнүүдэд вирусыг таньж устгахад тусалдаг.



# O

**Outbreak**

When the number of disease cases is higher than what has previously happened in a city or country, or in a group of people or time of year.

**Дэгдэлт**

Өвчний тохиолдлын тоо тухайн улс, хотод, тодорхой нэг бүлэг хүмүүсийн дунд эсвэл жилийн тухайн цаг үед өмнө нь тохиолдож байснаас өндөр байх.



# P

<p><b>Pandemic</b> Spread of a new disease to every country around the world.</p>	<p><b>Цар тахал</b> Дэлхийн бүх улсыг хамарсан шинэ өвчний тархалт.</p>
<p><b>Paediatric inflammatory multisystem syndrome temporally associated with SARS-CoV-2 (PIMS-TS)</b> This is the name of a rare illness in some children after having COVID-19 where parts of the body become larger than normal.</p>	<p><b>САРС-КоВ-2 вирустай холбоотой хүүхдийн олон эрхтэн системийн үрэвслийн хам шинж (PIMS-TS)</b> Энэ бол КОВИД-19-р өвчилсний дараа бие махбодын зарим хэсэг нь хэвийн хэмжээнээсээ томрох шинжээр илэрдэг зарим хүүхдэд тохиолддог ховор өвчин юм.</p>
<p><b>Paraesthesia</b> A feeling in the skin that is not normal, like feeling something crawl under the skin or tingling or numbness.</p>	<p><b>Парестезия</b> Арьсанд илрэх хэвийн бус мэдрэмжүүд тухайлбал арьсан доор ирвэгнэсэн, чимчигнэсэн эсвэл бадайрсан мэдрэмжүүд төрөх.</p>
<p><b>Passive immunisation</b> Occurs when a person is given antibodies to a disease rather than producing them through his or her own immune system. Such as a newborn baby receiving antibodies from their mum.</p>	<p><b>Идэвхигүй дархлаажуулалт</b> Эсрэг биеийг өөрийн дархлааны системээрээ ялгаруулаагүй, бусад аргаар авсан үед тохиолдоно. Тухайлбал шинээр төрсөн хүүхэд эсрэг биеийг эхээрээ дамжуулан авах.</p>
<p><b>Pathogen</b> A germ that can cause disease if you are infected, such as a virus.</p>	<p><b>Патоген</b> Халдвар авсан тохиолдолд танд өвчин үүсгэх чадвартай бичил биетэн. Жишээ нь: вирус.</p>
<p><b>Peer-review</b> Independent experts examine other people's research to make sure it is appropriate and correct.</p>	<p><b>Хянан магадлагаа</b> Бие даасан мэргэжилтнүүд бусад хүмүүсийн судалгаанд шүүмж болон үнэлгээ өгөх.</p>
<p><b>Pericarditis</b> A disease where the lining of the heart muscle becomes inflamed.</p>	<p><b>Перикардит</b> Зүрхний булчинг бүрхсэн хальсны үрэвсэл үүсгэдэг өвчин.</p>
<p><b>Placebo</b> A substance or treatment that has no effect on human beings.</p>	<p><b>Плацебо</b> Хүний биед ямар нэгэн нөлөөгүй бодис эсвэл эмчилгээ.</p>
<p><b>Polysaccharide vaccine</b> A vaccine containing long threads of sugar molecules, which look like the surface of some kinds of bacteria. Polysaccharide vaccines are available for pneumococcal disease (such as pneumonia).</p>	<p><b>Полисахарид вакцин</b> Нэг төрлийн бактерийн гадаргуутай адил харагддаг сахарын молекулын урт хэлхээг агуулсан вакцин. Полисахарид вакциныг пневмококк өвчний (уушигны хатгаа зэрэг) эсрэг хэрэглэж болдог.</p>



## P *Cont'd*

### **Post-market vaccine effectiveness studies (also known as 'real world' studies or Phase IV clinical trials)**

These types of studies are used to see whether the approved vaccine works in the real world and to look for any side effects.

### **Зах зээлийн дараах вакцины үр дүнгийн судалгаа (мөн 'бодит байдал'-ын судалгаанууд эсвэл 4-р үеийн клиник судалгаанууд ч гэж нэрлэгддэг)**

Эдгээр төрлийн судалгаануудаар хүлээн зөвшөөрөгдсөн вакцинууд бодит байдал дээр үр дүнтэй байгаа эсэх, мөн аливаа гаж нөлөөнүүд байгаа эсэхийг судалдаг.

### **Pre-Clinical Trial**

A research study done before a clinical trial. The study tests whether a vaccine is safe to test on humans. As part of the COVID-19 trials, animal models included experiments on animals including mice and macaques.

### **Эмнэлзүйн өмнөх туршилт**

Эмнэлзүйн туршилтын өмнө хийгддэг судалгаа. Энэ судалгаагаар тухайн вакциныг хүн дээр туршихад аюулгүй эсэхийг судалдаг. КОВИД-19 туршилтуудын нэг хэсгийг хулгана болон нохой сармагчин гэх мэт амьтад дээр туршсан.

### **Prevalence**

The total number of people in a population that have a disease at a certain time.

### **Тархалт**

Тухайн цаг үед тодорхой нэг хүн амын дундах нийт өвчилсөн хүний тоо.

### **Primary course**

The number of vaccines it takes to achieve a good level of protection against disease.

### **Үндсэн курс**

Аливаа өвчний эсрэг бүрэн хамгаалалттай болоход шаардагдах вакцины тоо.

### **Prime**

The first time a vaccine is given.

### **Анхдагч**

Вакцин хийсэн анхны удаа.

### **Protein subunit vaccine**

Include harmless pieces (proteins) of the germ instead of the entire germ. Once vaccinated, our bodies recognize that the protein should not be there and build blood elements called T-lymphocytes and antibodies that will remember how to fight the germ if we are exposed in the future.

### **Уургийн дэд нэгжийн вакцин**

Үүнд бичил биетэн бүхлээрээ бус түүний хоргүй хэсгүүд (уургууд) ордог. Вакцин хийсний дараа бидний бие махбодь тухайн уургийг байх ёсгүй гэж танин цусны элементүүд болох Т лимфоцит эсүүд болон эсрэг биетүүдийг ялгаруулснаар ирээдүйд тухайн бичил биетнийг танин устгах чадвартай болдог.



# R

## Roll out

The introduction of a new drug or vaccine. For the COVID-19 vaccination program this includes multiple phases: 1a, 1b, 2a, 2b, 3. Priority groups are identified by considering current public health and medical evidence on who would be most affected if they got COVID-19.

## Нэвтрүүлэлт

Шинэ эм тан эсвэл вакцин нэвтрүүлэх. КОВИД-19 дархлаажуулалтын хөтөлбөрт энэ нь хэд хэдэн үе шаттай: 1а, 1б, 2а, 2б, 3. Нэн түрүүнд хамрагдах бүлгийг тодорхойлохдоо КОВИД-19-д хэн хамгийн их өртөх магадлалтайг баталсан сүүлийн үеийн нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны судалгаанууд дээр үндэслэдэг.

## Reactogenicity

A group of effects that often happen after vaccination. It can include pain, redness or swelling around where the vaccine was injected. A person might feel tired, or hot or have a headache. Importantly, these are signs that an immune response is working.

## Вакцины дараах хариу урвал

Вакцинжуулалтын дараа тохиолддог түгээмэл бүлэг шинж тэмдгүүд. Үүнд вакцин тарьсан хэсэгт хөндүүрлэх, улайх, хавдах шинжүүд орно. Тухайн хүн бага зэрэг ядрах, бүлээрэх эсвэл толгой өвдөх шинж илэрч болно. Хамгийн чухал нь эдгээр шинж тэмдгүүд нь дархлааны систем ажиллаж байгаагийн илрэл юм.

## Regulatory body

A government organisation that decides which vaccines can be registered in a country and legally used in the country.

## Улсын хяналтын байгууллага

Тухайн улсад ямар вакцинууд хууль ёсоор бүртгэгдэн ашиглагдах тухай шийддэг засгийн газрын байгууллага.



# S

**SARS-CoV-2**

The official name of the virus that causes the disease known as COVID-19. It belongs to family of viruses called coronaviruses.

**Spike protein**

Coronaviruses have sharp bumps on their surface. Those bumps are called spike proteins. They help the virus enter a person's cells.

**Serology**

Measuring the level of antibodies (immune proteins) present in the blood.

**Side Effect**

Any unwanted or unexpected effects of a vaccine.

**САРС-КоВ-2**

КОВИД-19 гэх өвчнийг үүсгэгч вирусын албан ёсны нэр. Энэ нь коронавирус гэх вирусуудын ангилалд харьяалагддаг.

**Гадаргуугийн уураг**

Коронавирус гадаргуудаа өргөслөг товгоруудтай. Эдгээр товгоруудыг гадаргуугийн уургууд гэж нэрлэдэг ба эдгээр нь вирусыг хүний эсэд нэвтрэн ороход тусалдаг.

**Ийлдэс судлал**

Цусан дах эсрэг биетүүдийн түвшингийн (дархлааны уургууд) хэмжилт.

**Гаж нөлөө**

Вакцины урьдчилан тооцоолоогүй сөрөг нөлөөнүүд.



# T

**Therapeutic Goods Administration (TGA)**

The Therapeutic Goods Administration (TGA) is responsible for checking vaccines and other medicines before they can be used in Australia.

**Эм, эмийн Бүтээгдэхүүний Хяналтын Газар (TGA)**

Эм, эмийн Бүтээгдэхүүнийг Хянах Газар (TGA) нь аливаа вакцин болон бусад эмийн бүтээгдэхүүнийг Австрали улсад хэрэглэж эхлэхээс өмнө хяналт тавих, шалгах үүрэгтэй.

**Thrombosis with thrombocytopenia syndrome (TTS)**

A newly described serious condition. A person gets unusual blood clots in the brain or in other parts of the body. It is also associated with low platelet levels.

**Тромбоцитопени хам шинжтэй цусны бүлэгнэлт (TTS)**

Шинээр гарч ирсэн ноцтой нөхцөл байдал. Тухайн хүний тархи болон биеийн бусад хэсэгт хэвийн бус цусны бүлэгнэлт үүсэх. Энэ нь мөн цусны ялтас эсийн түвшин багассантай холбоотой.

**Transmission**

The ability of a virus to pass from one person to another.

**Дамжилт**

Вирусын хүнээс хүнд дамжих чадвар.



# V

## **Vaccine**

A type of medicine that supports our immune system to fight against certain germs and prevent disease. Usually, vaccines are given before the person encounters the germ. Each vaccine promotes the immune system to make antibodies against the germ.

## **Вакцин**

Аливаа бичил биетний эсрэг тэмцэн өвчнөөс урьдчилан сэргийлэхэд бидний дархлааны системд дэмжлэг үзүүлдэг эмийн төрөл. Вакциныг тухайн хүнд бичил биет халдахаас өмнө хийдэг. Вакцин бүр нь аливаа бичил биетний эсрэг тэмцэх эсрэг биетүүд ялгаруулахад дархлааны системийг дэмждэг.

## **Vaccination**

Giving a vaccine to help the immune system develop protection from a specific disease. Commonly used terms include shot, jab, needle, and inoculation.

## **Вакцинжуулалт**

Аливаа өвчнөөс хамгаалах дархлааны системийг дэмжих зорилгоор вакцин хийх. Түгээмэл ашигладаг нэр томъёонд тун (shot), хатгалт (jab), зүү (needle), тарилга хийх (inoculation) зэрэг орно.

## **Vaccine Candidate**

A new vaccine that is still being tested and is not licensed.

## **Вакцины төлөөлөгч**

Зөвшөөрлөө аваагүй, туршилтын шатандаа байгаа шинэ вакцин.

## **Vaccine hesitancy**

When a person is unsure about a vaccine and delays or refuses to receive the available vaccine.

## **Вакцины эргэлзээ**

Тухайн хүн вакцины талаар эргэлзэн, санал болгосон вакциныг хийлгэхээс татгалзах эсвэл хойшлуулах.

## **Variant (mutation)**

Tiny changes in the genetic information inside a virus. Variants can occur when a virus multiplies or makes copies of itself.

## **Хувилбар (мутац)**

Вирусын генетикийн мэдээлэлд бага зэрэг өөрчлөлт орох. Тухайн вирус хуваагдалд орон, өөрийгөө олшруулснаар шинэ хувилбарууд болдог.

## **Vial**

A small container used to hold medicine.

## **Хуруу шил**

Эмийг агуулах жижиг сав.





## V *Cont'd*

### **Viral vector vaccine**

Contains a modified version of a different virus from the one that causes COVID-19. Inside the modified virus, there is material from the virus that causes COVID-19. This is called a “viral vector.” Once the viral vector is inside our cells, the genetic material gives cells instructions to make a protein that is unique to the virus that causes COVID-19. Using these instructions, our cells make copies of the protein. This prompts our bodies to build T-lymphocytes and B-lymphocytes that will remember how to fight that virus if we are infected in the future.

### **Вирусын вектор вакцин**

КОВИД-19-н үүсгэгчээс өөр төрлийн вирусын хувиргасан хувилбарыг агуулдаг вакцин. Хувиргасан вирус дотор КОВИД-19 вирусын нэг хэсгийг хийдэг ба үүнийг “вирусын вектор” гэж нэрлэнэ. Вирусын вектор хүний биед орсны дараа генетикийн бүрэлдэхүүнүүд нь эсүүдэд яг КОВИД-19-г үүсгэгч вируст өвөрмөц уураг ялгаруулах зааварчилгаа өгдөг. Энэ зааварчилгааг ашиглан бидний эсүүд тухайн уургийг хуваагдалд оруулан олшруулдаг. Ингэснээр хүний бие Т лимфоцит болон В лимфоцит эсүүдийг үүсгэн ирээдүйд тухайн вирусээр халдвар авахад хэрхэн тэмцэхээ санах чадвартай болдог.

### **Viral shedding**

When the virus made inside your body starts to be released into your surroundings. At that point, it may be spread or passed on to other people.

### **Вирусын урсгал**

Вирус хүний биед орж боловсорсны дараа эргэн тойронд тархан урсаж эхэлдэг. Яг энэ үед вирус бусад хүмүүст тархах болон дамжих боломжтой болдог.



# W

**Waning immunity**

When your level of immunity gets lower and lower with time.

**Суларсан дархлаа**

Таны дархлалын түвшин цаг хугацаа өнгөрөхөд буурах.